



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 08 өдөр

Дугаар 4/чөч

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай” 211, 2020 оны “Зөвлөмж батлах тухай” 229 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт баригдсан БСШУСЯ/202001272 дугаар гэрээт ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн спорт заалны барилгын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандаххүү (аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Ц.Амарсанаа (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
	Д.Отгонжаргал (Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	Б.Батбилэг (Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
	Э.Тэрбиш (Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн захирал) (ашиглагч)
	Б.Балдорж (Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл хяналт хариуцсан мэргэжилтэн)
	Д.Цэвэлмаа (“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн ерөнхий инженер)

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0201091524

2.


- Б.Бээжин ("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер)
- А.Отгонбаатар ("Мандал-Голомт" ХХК-ийн ерөнхий инженер)
- Д.Байгальмаа ("Ундарга-Алтай" ААТҮГ-ын ашиглалтын инженер)
- А.Нарандэлгэр ("Барилга байгууламж" ХХК-ийн захирал) (зохиогч)
- Б.Энхбаяр ("Жигүүр-Эрдэнэ" ХХК-ийн гүйцэтгэх захирал) (гүйцэтгэгч)
- Г.Пүрэвхүү ("Жигүүр-Эрдэнэ" ХХК-ийн талбайн даамал) (гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Н.Пүрэвдулам (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2022 оны 08 дугаар сарын 15-ны дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3. Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг бүртгэж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль (Э.Тэрбиш)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР